



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Хугацаа сунгах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 33.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 4 дүгээр зүйлийн 4.1, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5.1 дэх хэсэг, Улсын онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор Коронавирус (КОВИД-19)-ын цар тахлын халдварыг хязгаарлах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд шилжүүлсэнийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд сунгасантай холбогдуулан дор дурдсан хугацаа сунгах арга хэмжээг авсугай. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/42 тушаалаар зарласан СШ-51 дүгээр сонгон шалгаруулалтын санал хүлээн авах, техникийн санал нээх үйл ажиллагааны хугацааг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаагаар сунгасугай.

2. Энэхүү тушаалын 1 дүгээр хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалтын санал хүлээн авах, техникийн болон үнийн саналыг нээх, үнэлэх хугацааг сунгасантай холбогдуулан байгууллагын веб сайт ашиглан цахимаар олон нийтэд мэдээлэхийг Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Батмагнай/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Түвшинжаргал/-д даалгасугай.

ДАРГА Х.ХЭРЛЭН



Тараасан нь:

1. Архивд – 1 хувь
2. ГУУКХ -1 хувь

/...../

Боловсруулсан: ГУУКХ-ийн мэргэжилтэн
Хянасан: Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
/ түр орлон гүйцэтгэгч/
2 хувь



Б.Батсайхан
Р.Энхтайван